

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК -ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2024/17/НА-СТА-ТӨА

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он	Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас:51-261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: П.Чанцалдулам Утас:51-261885 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn Аудитор: Д.Болормаа Утас: 51-261740 Цахим хаяг: bolormaad@audit.gov.mn Азуре хүлүг аудит ХХК-ийн захирал: Г.Мөнхбаяр Утас:70110090 Цахим хаяг: audit@azure.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ
СҮЛЖЭЭ ХХК-ИЙН ЗАХИРАЛ
Б.МӨНХБАТ ТАНАА

2024.03.15 № 07/744
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 362 дугаар тогтоолын дагуу Гаалийн ерөнхий газрын харьяа газар хороодын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй байсан 5 нэрийн 5,498.2 сая төгрөгийн хөрөнгийг балансаас баланст шилжүүлж авсан байна.

Мөн сумдын түвшний газрын сүлжээ байгуулах төслийн хүрээнд хийгдсэн 13 аймгийн 33 сумын 1,516.12 километр газрын шилэн кабелийн сүлжээнд хөрөнгийн үнэлгээ хийж 3,875.4 сая төгрөгөөр, Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу 8,021,595 м.кв газрын эзэмших эрхийн бодит үнэ цэнийг 12,863.5 сая төгрөгөөр үнэлж бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 563 дугаар тогтоолоор баталсан 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшиний төлөвлөгөөнд нийт орлогыг 61,353.1 сая төгрөг, нийт зардлыг 59,751.7 сая төгрөг, цэвэр ашгийг 1,134.8 сая төгрөгийн ашигтай ажиллахаар баталсан байна.

Гүйцэтгэлээр 60,228.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 58,653.1 сая төгрөгийн зардал гарган, 1,575.4 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Компанийн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 176 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 99.6 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	7,323,300,020.98	2,894,777,273.10
1.1.2	Дансны авлага	8,994,107,581.38	10,270,029,214.66
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	143,065,837.45	376,604,674.92
1.1.4	Бусад авлага	556,845,639.57	290,167,730.03
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал	3,494,489,048.05	3,533,169,040.43
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	1,014,807,061.26	872,506,424.53
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	21,526,615,188.69	18,237,254,357.67
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	118,511,574,350.85	126,711,907,761.75
1.2.2	Биет бус хөрөнгө	37,685,688,176.93	50,577,627,584.96
1.2.3	Биологийн хөрөнгө	-	-
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	-	-
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	1,670,089,038.57	2,094,943,742.63
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	5,034,922,637.08	4,485,842,480.47
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	162,902,274,203.43	183,870,321,569.81
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	184,428,889,392.12	202,107,575,927.48
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	1,140,144,736.30	1,497,140,543.42
2.1.1.2	Цалингийн өглөг	-	-
2.1.1.3	Татварын өр	378,610,834.73	115,760,830.96
2.1.1.4	НДШ - ийн өглөг	346,500.45	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	9,400,180.00	6,237,684.92
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/	-	-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	1,051,356,930.62	1,045,371,140.93
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	2,579,859,182.10	2,664,510,200.23
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	36,109,324,817.03	33,985,228,886.65
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	3,671,364,261.47	3,875,172,492.66
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.2.5	Хойшлогдсон орлого	37,400,519,305.57	35,181,688,628.89
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	77,181,208,384.07	73,042,090,008.20
2.2	Өр төлбөрийн нийт дүн	79,761,067,566.17	75,706,600,208.43
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	137,551,494,711.54	137,551,494,711.54
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	16,116,558,631.08	16,115,545,818.58
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	42,054,545,025.75	63,732,485,940.51
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(91,054,776,542.42)	(90,998,550,751.58)
2.3.11	Эздийн өмчийн дүн	104,667,821,825.95	126,400,975,719.05
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	184,428,889,392.12	202,107,575,927.48

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	57,340,639,030.58	57,826,314,900.67
2	Борлуулалтын өртөг	50,851,457,212.32	50,980,915,466.50
3	Нийт ашиг (алдагдал)	6,489,181,818.26	6,845,399,434.17
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүгийн орлого	258,953,424.63	81,431,124.99
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	2,262,940,242.60	2,243,466,716.54
9	Борлуулалт, маркетингийн зардал	462,328,382.42	481,103,269.85
10	Ерөнхий ба удирдлагын зардал	3,767,740,523.35	5,245,792,872.64
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	1,850,827,692.18	1,885,325,830.31
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	891,704.87	1,119,761.25
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	2,409,909.10	16,175,454.53
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	2,933,480,501.51	1,575,370,518.68
19	Орлогын татварын зардал	451,898,953.59	197,065,772.82
19.1	Хойшлогдсон татварын зардал	125,487,116.43	145,044,547.52
20	Татварын дараах ашиг (алдагдал)	2,356,094,431.49	1,233,260,198.34
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	2,356,094,431.49	1,233,260,198.34
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
24	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
25	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
26	Бусад олз (гарз)	-	-
27	Орлогын нийт дүн	2,356,094,431.49	1,233,260,198.34

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	137,551,494,711.54	16,116,558,631.08	42,047,596,216.11	(92,932,835,117.10)	102,782,814,441.63
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	(35,856.81)	(35,856.81)
3	Залруулсан үлдэгдэл	137,551,494,711.54	16,116,558,631.08	42,047,596,216.11	(92,932,870,973.91)	102,782,778,584.82
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	2,356,094,431.49	2,356,094,431.49
5	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
6	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	6,948,809.64	-	6,948,809.64
7	Зарласан ногдол ашиг	-	-	-	(478,000,000.00)	(478,000,000.00)
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-
9	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	137,551,494,711.54	16,116,558,631.08	42,054,545,025.75	(91,054,776,542.42)	104,667,821,825.95
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	1,012,812.50	1,012,812.50
11	Залруулсан үлдэгдэл	137,551,494,711.54	16,116,558,631.08	42,054,545,025.75	(91,053,763,729.92)	104,668,834,638.45
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	1,233,260,198.34	1,233,260,198.34
13	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
14	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	21,677,940,914.76	-	21,677,940,914.76
15	Зарласан ногдол ашиг	-	-	-	(1,178,047,220.00)	(1,178,047,220.00)
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(1,012,812.50)	-	-	(1,012,812.50)
17	2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	137,551,494,711.54	16,115,545,818.58	63,732,485,940.51	(90,998,550,751.58)	126,400,975,719.05

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	57,764,035,656.85	60,546,562,934.54
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	57,560,742,438.70	60,152,553,560.47
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	23,060,100.72	18,790,520.60
	Бусад мөнгөн орлого	180,233,117.43	375,218,853.47
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	47,559,142,823.20	51,714,068,683.49
	Ажиллагчдад төлсөн	17,210,755,354.32	18,699,502,740.21
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	5,094,546,186.05	5,524,578,076.42
	Бараа материал худалдан авахад төлсөн	2,094,289,341.46	2,131,982,746.55
	Ашиглалтын зардалд төлсөн	12,353,749,667.44	12,072,646,401.84
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	2,275,888,337.04	3,312,576,327.49
	Хүүгийн төлбөрт төлсөн	858,214,655.64	809,864,534.08
	Татварын байгууллагад төлсөн	5,921,424,269.95	6,909,039,770.61
	Даатгалын төлбөрт төлсөн	56,533,977.98	62,535,266.56
	Бусад мөнгөн зарлага	1,693,741,033.32	2,191,342,819.73
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	10,204,892,833.65	8,832,494,251.05
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	258,953,424.63	99,224,124.99
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	17,793,000.00
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
	Хүлээн авсан хүүгийн орлого	258,953,424.63	81,431,124.99
	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
	Бусад	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	7,370,473,438.34	10,063,432,280.37
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	6,972,249,574.95	9,511,742,185.37
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	398,223,863.39	551,690,095.00
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
	Бусад	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(7,111,520,013.71)	(9,964,208,155.38)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	117,631,428.33	43,569,083.50
	Төрөл бүрийн хандив	-	-
	Бусад	117,631,428.33	43,569,083.50
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,755,950,387.24	3,340,377,927.05
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	2,124,077,930.26	2,124,095,930.38
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-
	Төлсөн ногдол ашиг	478,000,000.00	1,178,047,220.00
	Бусад	153,872,456.98	38,234,776.67
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(2,638,318,958.91)	(3,296,808,843.55)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	455,053,861.03	(4,428,522,747.88)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6,868,246,159.95	7,323,300,020.98
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	7,323,300,020.98	2,894,777,273.10

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/сая төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлтүүд	2022 оны Гүйцэтгэл	2023 он			
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт					
	Сувгийн үйлчилгээ	26,624.4	28,681.5	29,536.6	103.0	855.1
	Улс хоорондын сүлжээний үйлчилгээ	9,574.8	10,617.4	4,416.0	41.6	(6,201.4)
1	Худаг сувагчлал	4,923.6	4,828.1	5,349.3	110.8	521.2
	Байр талбай, антен түрээс	10,012.1	9,711.5	11,939.9	122.9	2,228.4
	Хэрэглэгчийн шугам	784.0	735.5	239.8	32.6	(495.7)
	Техник менежмент	5,421.7	4,403.7	6,344.7	144.1	1,941.1
	Үйл ажиллагааны бус орлого	2,696.2	2,375.5	2,402.1	101.1	26.6
2	Нийт орлого	60,036.9	61,353.1	60,228.5	98.2	(1,124.7)
3	Нийт зардал	57,103.4	59,751.8	58,653.1	98.2	(1,098.7)
3.1	Үүнээс: Удирдлагын зардалд	820.3	772.2	771.8	99.9	(0.4)
4	Татварын өмнөх ашиг	2,933.5	1,601.4	1,575.4	98.4	(26.0)
5	Цэвэр ашиг /алдагдал/	2,356.1	1,134.9	1,233.3	108.7	98.4
6	Төсвийн төлбөр	11,016.0	10,859.1	12,433.5	114.5	1,574.3
7	Төрийн өмчийн ногдол ашиг	478.0	539.5	1,178.0	218.4	638.6
8	Ажиллагсдын тоо	1335	1335	1318	98.7	(17.0)
9	Нийт цалингийн сан	17,433.3	19,381.7	18,667.9	96.3	(713.8)
10	Нэг ажилтны сарын дундаж цалин	1,088.2	1.2	1.2	97.6	(0.0)
11	Борлуулалтын орлогын 1 төгрөгт ногдох зардал	0.95	0.97	0.97	100.0	(0.0)
12	Хөрөнгө оруулалт	6,971.8	17,550.6	12,842.0	73.2	(4,708.6)
13	Нийт авлага	8,994.1	5,612.3	10,270.0	183.0	4,657.7
14	Нийт өглөг	42,360.5	38,765.6	40,524.9	104.5	1,759.3
14	Үүнээс: богино хугацаат өр төлбөрт	2,579.9	1,198.6	2,664.5	222.3	1,465.9
14	Урт хугацаат өр төлбөрт	39,780.7	37,566.9	37,860.4	100.8	293.5

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 144.2 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 144.2 сая төгрөгийн алдааг залруулсан.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалингийн тооцооллыг нийгмийн даатгалын тайлантай тулгаж шалгахад 1.9 сая төгрөгийн зөрүү үүссэн болно.	1	1,873.5	-	-	1	1,873.5	1	1,873.5	-	-	-	-
Санхүүгийн программд ашиглалтын хугацааг оруулаагүйгээс 260 нэр төрлийн хөрөнгөд 77.5 сая төгрөгийн элэгдлийн зардал дутуу тооцоолсон байна.	1	77,509.3	1	77,509.3	-	-	1	77,509.3	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг дахин тооцоолж үзэхэд 15 хөрөнгийн тайлант хугацааны элэгдлийг 67.8 сая төгрөгөөр дутуу тооцоолсон байна.	1	64,786.3	1	64,786.3	-	-	1	64,786.3	-	-	-	-
Дүн	3	144,169.1	2	142,295.6	1	1,873.5	3	144,169.1	-	-	-	-

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитаар нийт 85.6 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 85.6 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Мөнгөн зарлагын ажил гүйлгээг анхан шатны баримт руу тулган шалгахад баримтын бүрдэл хангалтгүй 85.6 сая төгрөгийн ажил гүйлгээ бүртгэлд тусгасан байна.	1	85,568.5	-	-	-	-	1	85,568.5	-	-	-	-
Анхны өртгөө элэгдлээрээ нөхсөн 5,696.4 сая төгрөгийн 1312 нэр төрлийн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоогоогүй байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Тухайн жилд нэмэгдсэн 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий худалдан авах бараа, үйлчилгээний жагсаалтыг худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлээгүй байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Дүн	3	85,568.5	-	-	-	-	3	85,568.5	-	-	-	-

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.